

The seal of the State Audit Agency of Mongolia is centered in the background. It features a yellow circular border with a black geometric pattern. Inside the circle is a blue triangle with a yellow flame-like symbol at its center. The text "ТӨРИЙН АУДИТ" (State Audit) is written in blue at the bottom of the seal.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ДҮНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2021

АГУУЛГА



- УЛСЫН ТӨСВИЙН ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРУУДЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ДҮН

УТҮГ, ОНӨААТҮГ-ЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ДҮН

Санхүүгийн тайлангийн аудитаар улсын төсвийн үйлдвэрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн 20 газрыг хамрууллаа.

Санал дүгнэлт
6

Түүвэр
13

Итгэмжлэл
1

2



• Төрийн аудитын газар

4



• Гэрээт аудитын компани

АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР

ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ - 5

Шалгагдагч байгууллагын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна гэж үзсэн.

ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ – 1

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол шалгагдагч байгууллагын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна гэж үзсэн.

СӨРӨГ САНАЛ ДҮГНЭЛТ- 0

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас шалгагдагч байгууллагын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаатай, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулаагүй байна үзсэн.

ТАТГАЛЗСАН САНАЛ ДҮГНЭЛТ - 0

Шалгагдагч байгууллагын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөхгүй. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас санхүүгийн тайланд аудитын дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохистой нотолгоо авах боломжгүй байна гэж үзсэн.

УТҮГ, ОНӨААТҮГ-ЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ДҮН



- Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 12,664,790.1 мянган төгрөгийн 29 зөрчил илрүүлж 4,969.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 12,193,452.9 мянган төгрөгийн 17 албан шаардлага, 299,124.0 мянган төгрөгийн зөвлөмж өгч ажиллалаа.

Төлбөрийн
акт-2

4,969.1
мянган төгрөг

Албан
шаардлага-
17

167.784.4
мянган төгрөг


Зөвлөмж-6

299,124.0
мянган төгрөг


Залруулга-4

167.784.4
мянган төгрөг


АЛДАА ЗӨРЧЛИЙН АНГИЛАЛ




Алдаа зөрчлийн дүн /Тоо, эзлэх хувь/



Алдаа зөрчлийн дүн /Мянган.төг/



АЛБАН ШААРДЛАГЫГ АНГИЛАН ТӨРӨЛЖҮҮЛБЭЛ



АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ



ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛИЙН 23 ДУГААР ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйл. Албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хангах

23.1. Төрийн аудитын байгууллага хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ.

Захиргааны ерөнхий хуулийн 82 дугаар зүйл. Захиргааны шийдвэр гүйцэтгэл

82.1. Нийтийн эрх зүйн хүрээнд захиргааны байгууллагаас гаргасан захиргааны шийдвэрийг гүйцэтгэхэд энэ журам үйлчилнэ.

82.2. Дараах тохиолдолд захиргааны актад шийдвэр гүйцэтгэнэ:

82.2.1. гомдол гаргах хугацаа өнгөрсөн;

82.2.2. захиргааны актыг түдгэлзүүлэх шийдвэр хүчингүй болсон.

83 дугаар зүйл. Захиргааны шийдвэр гүйцэтгэлд тавих шаардлага

83.1. Захиргааны шийдвэр гүйцэтгэхэд дараах шаардлагыг хангасан байна:

83.1.1. шийдвэр гүйцэтгэх эрхийг нотолсон шийдвэр байх;

83.1.2. үүрэг хүлээгчээс уг шаардлагыг биелүүлээгүй байх;

83.1.3. хуульд өөрөөр заагаагүй бол шаардах эрх бүхий шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн байх;

83.1.4. үүрэг хүлээгчид 14 буюу түүнээс доошгүй хоногийн хугацаанд захиргааны шийдвэрийг биелүүлэх тухай мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн байх.

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

